

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ТУШААЛЫН НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Нэгдсэн эмнэлгийн Захирлын албан тушаалд нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээлж байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 17.10.5, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 16.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/414 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн захирлын албан тушаалд нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

/Журмыг <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230721618231> энд дарж үзнэ үү/

Хууль, журамд заасан шалгуур, шаардлага хангасан иргэнийг сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Нэг. Тавигдах шаардлага:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт заасны дагуу эмнэлгийн Захирлын албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцох иргэн дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

- Эрүүл мэндийн салбарт 10-аас доошгүй жил ажилласан;
- Эрүүл мэндийн байгууллагад 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан;
- Нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэн;
- Тодорхой албан тушаал эрхлэх буюу үйл ажиллагаа явуулах эрх нь шүүхийн шийдвэрээр хасагдаагүй;
- Улс төрийн намын гишүүн бус;
- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад удирдах албан тушаал эрхэлдэггүй;
- Бусад байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын бүрэлдэхүүнд хавсран ажилладаггүй.

Хоёр. Сонгон шалгаруулалтад оролцоход бүрдүүлэх баримт бичиг:

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй, шаардлага хангасан иргэн доор дурдсан баримт бичгийг бүрдүүлж өгнө.

2.1. Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албаны зөвлөлөөс баталсан маягтын дагуу);

2.2. Иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл улсын бүртгэлийн лавлагаа;

2.3. Тухайн албан тушаалд томилогдох хүсэлт, бүрдүүлсэн баримт бичгийн үнэн болохыг илэрхийлсэн өргөдөл;

2.4. Тухайн иргэний мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлагыг баталгаажуулсан 2 хүний тодорхойлолт (өмнө нь ажиллаж байсан эсхүл одоо харьяалж буй байгууллагын дарга/захирал, тухайн иргэний гишүүнчлэлтэй мэргэжлийн нийгэмлэг, холбооны удирдах зөвлөл эсхүл гүйцэтгэх захирлын);

2.5. Цээж зураг (4х3 хэмжээтэй 2 хувь);

2.6. Нийгмийн эрүүл мэндийн болон Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэнийг нотлох баримт бичиг

(боловсролын диплом, мэргэшлийн үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эх хувийн хамт);

2.7. Эрүүл мэндийн салбарт 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт бичиг (Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох хэсгийг хуулбарлан эх хувийн хамт);

2.8. Эрүүл мэндийн байгууллагад 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласныг нотлох баримт бичиг (хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох хэсгийг хуулбарлан эх хувийн хамт);

2.9. Англи хэлний мэдлэгийн түвшин тодорхойлох баримт бичиг ("TOEIC", "TOEFL", "IELTS" олон улсын шалгалтын гэрчилгээний хуулбар, эх хувийн хамт эсвэл олон улсад хүлээн зөвшөөрөгддөг бусад англи хэлний түвшин тогтоох шалгалт өгснийг гэрчлэх албан ёсны баримт бичгийн хуулбар, эх хувийн хамт эсвэл гадаад улсын их, дээд сургууль, коллежид бакалавр, магистр, докторын боловсролын зэргийн сургалтад англи хэлээр суралцаж төгссөн диплом, түүнтэй дүйцүүлэх албан ёсны баримт бичгийн хуулбар, эх хувийн хамт);

2.10. Тухайн эмнэлгийг хөгжүүлэх төсөл (хагас бие даан хөгжүүлэх бодлого, бүтэц, зохион байгуулалт, хуний нөөц, санхүү, тусламж, үйлчилгээний төлөвлөлт, хүрэх үр дүн, үр ашиг г.м);

2.11. Улс төрийн намын гишүүн бус, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад удирдах албан тушаал эрхэлдэггүй, бусад байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын бүрэлдэхүүнд хавсран ажилладаггүйг илэрхийлж бичсэн баталгаа;

2.12. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн талаарх лавлагаа;

2.13. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг.

Жич: Төлөөлөн удирдах зөвлөл нь дээр дурдсан баримт бичгийн бүрдлийг шалгаж дутуу эсвэл хуурамч материал бүрдүүлсэн иргэнийг бүртгэхээс татгалзаж, энэ тухай өөрт нь мэдэгдэнэ. Эх хувиар ирүүлсэн баримт бичгийг сонгон шалгаруулалт дууссаны дараа буцаан өгнө.

Гурав: Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах, бүртгэл явагдах хугацаа:

Баримт бичгийг цаасан болон цахимаар /баримт бичгийн дарааллаар PDF болгож DVD-д хуулбарлан/ бүрдүүлж ирүүлнэ. Бүрдүүлсэн баримт бичиг болон баримт бичгийн жагсаалт, тус бүрийн хуудасны тоог дурдаж өөрийн гарын үсэг зурсан товъёгийг дугтуйнд хамт хийж битүүмжлэн 2025 оны 4 дүгээр сарын 2-ний өдрийн 18:00 цагаас өмнө аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийг дэмжих төвийн 203 тоотод хүлээлгэн өгч бүртгүүлнэ.

Баримт бичгийг хүлээн авах бүртгэхтэй холбоотой гомдлыг ажлын 1 өдрийн дотор гаргаж болох бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэнэ.

Дөрөв. Сонгон шалгаруулалт явуулах газрын хаяг:

Сонгон шалгаруулалтыг Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлагын байрны 2 давхарт байрлах хурлын танхимд 2025 оны 4 дүгээр сарын 3-ний өдрийн 10:00 цагаас зохион байгуулна.

Тав. Хариуцах мэргэжилтний утасны дугаар:

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга М.Оюунболд. Холбоо барих утас: 88053111

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**